Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

# БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ`

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв, сая төгрөг | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **НЭГ. КОРОНАВИУРСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО** | | | | | | | |
| **1.1. Коронавируст халдвар (КОВИД-19) цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 1 | МУТЖҮЧ-2.4.1, ЗГҮАХТ.1.1.2.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээж авна. | 600.0 | Холбогдох чиглэлээр шинээр хийж эхэлсэн болон 2024 онд үр дүнг нь хүлээн авсан судалгааны тоо | 9 судалгааны төсөлт ажлын судалгааны үр дүнг хүлээн авсан. | Манай орны нөхцөлд тохирсон ДЭМБ-ын шаардлагыг хангасан оношлуур, эм, био бэлдмэл бусад тоног төхөөрөмж, хэрэглүүр зохион бүтээж үйлдвэрлэн хангах судалгаа хийнэ. Манай оронд тохиолдож буй улирлын коронавирусийн халдварын эпидемиологи, эмнэл зүйн онцлогийг судлан | Уламжлалт анагаах ухааны чиглэлийн эрдэмтэд КОВИД-19 халдварын үед уламжлалт анагаах ухааны эм заслын эмчилгээний үр дүнг тооцох судалгааг хийж, КОВИД-19 халдварыг эмчлэх уламжлалт анагаах ухааны "Чун-7" эмийг шинээр бүтээж, уламжлалт анагаах ухааны эмнэлзүйн зааврыг боловсруулсан. Мөн Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн эрдэмтэд SARS-CoV-2 эсрэгбие агуулсан эмчилгээний сийвэнг шинээр боловсруулж гаргасан байна.<br>КОВИД-19 халдварыг оношлох зориулалтаар ШУА-ийн Биологийн хүрээлэн "Шинэ | 100 |



82

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тогтоож, сэргийлэх, эмчлэх оновчтой арга замыг тогтооно. | төрлийн SARS-CoV-2 вирусийн эсрэг бие илрүүлэх оношлуур №2021/001", АШУҮИС-ын "SARS-CoV-2-ийг шүлснээс шууд илрүүлэх бодит хугацааны ПГУ-ын цомог оношлуурын бүрдлийг тус тус бүтээсэн байна. Анагаах ухааны ёс зүйн хяналтын хорооны хурлаар 2024 онд "Монгол Улсад КОВИД-19 халдварыг үүсгэж буй SARS-CoV-2 вирусийн геномын хувилбарын тандалт", "(КОВИД-19) вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа", "Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг вакцины дараах дархлаа тогтцын судалгаа", "SARS-CoV-2 ба Хепатитын дельта вирусийн халдварыг илрүүлэх шинэ үеийн серологийн оношлууруудыг зохион бүтээх" гэсэн нэр сэдэвтэй 4 судалгааны төслийн хэрэгжилтийн үр дүн, тайланг хэлэлцэн хүлээн авч, судалгааг хаах зөвшөөрлийг олгож, "Ердийн товлолт болон коронавируст халдвар (КОВИД-19), хүний хөхөнцөр вирусийн эсрэг дархлаажуулалтын хөтөлбөрт жендерийн дүн шинжилгээ хийх үнэлгээ" гэсэн сэдэвт 1 судалгааны төсөлд судалгаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон байна. Эдгээрээс "КОВИД-19-ийн халдвар болон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | вакцинжуулалтын дараах дархлаа тогтцын үнэлгээ", "Монгол улсад SARS-CoV-2-ийн голомтолсон халдварын геномын судалгаа", "(КОВИД-19) вакцины дархлаа сэргээх нэмэлт тунгийн дараах дархлааны хариу урвал болон урвал хүндрэлийг судлах нь", "(КОВИД-19) вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа", "Монгол улсад (КОВИД-19) халдварыг үүсгэж буй SARS-CoV-2 вирусийн геномын хувилбарын тандалтын судалгаа" гэсэн 5 төслийн хэрэгжилтийн үр дүн, тайланг яамны ШУТЗ-ийн хурал (11 дүгээр сарын 12-ны өдөр)-аар хэлэлцүүлж, дэмжин хүлээн авсан байна. | |
| 2 | МУХТЖҮЧ-2.2.1, ЗГҮАХТ.1.1.3.5, ЭМССТ 1.3. Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна. | 500.0 | Засгийн газрын хуралдааны шийдвэр | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль батлагдсан. | Үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулах өвчний хяналтын төв байгуулагдаж үйл ажиллагаа жигдэрсэн байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн А/37 дугаар тушаалаар "Өвчний хяналт, сэргийлэлтийн төв" байгуулах ажлын хэсгийг шинэчлэн байгуулсан. Ажлын хэсгээс эхний төслийг боловсруулан 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, Аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн эрүүл мэндийн төв, ӨЭМТ-ийн удирдах албан тушаалтан, эмч, мэргэжилтэн 67 албан хаагчийг оролцуулан ӨХСТ-ийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцүүлэг зохион байгуулсан. Уулзалт хэлэлцүүлгээс гарсан саналыг тусган, ӨХСТ-ийн зардлын тооцооны хамт тус байгууллагын дүрмийн төсөл, Засгийн газрын тогтоолын төслийг ЭМЯ-ын УЗ-ийн хурлаар 2024 оны 06 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцүүлсэн. УЗ-ийн шийдвэр Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулах төсвийн тооцоог нарийвчлан гаргахыг Санхүү, эдийн засгийн газарт, дүрмийн төсөлд гишүүдээс гарсан саналыг тусган 6 сарын 18-ны өдөр УЗ-ын хурлаар дахин хэлэлцүүлэхийг бодлого төлөвлөлтийн газарт тус тус үүрэг болгосон.<br>ЭМЯ-ны УЗ зөвлөлийн шийдвэрийн дагуу Үндэсний хэмжээнд байгуулагдах ӨХСТ-ийн эдийн засгийн тооцоолол, шаардагдах төсвийг гаргуулахаар АХБ-ын МОН-6652: “Халдварт бус өвчний хяналт эмийн аюулгүй байдлыг сайжруулах нь” техник туслалцааны төслөөс техникийн дэмжлэг авсан. Төслийн зөвлөх багаас НЭМҮТ, ЗӨСҮТ, ХӨСҮТ өөрчлөн зохион байгуулах замаар ӨХСТ байгуулахад 20 тэрбум шаардлагатай зардлын тооцоо гарсан. 2024 оны 8 дугаар сарын улсын төсвийн тодотголд ӨХСТ, аймаг, дүүргийн НЭМТ байгуулахад шаардлагатай санхүүжилтийг тусгуулахаар | |



89

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Сангийн яаманд хүргүүлсэн боловч төсвийн тодотголоос хасагдсан байна.<br>Мөн ӨХСТ-ийн дүрэм, бүтцийн төсөл дээр хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу олон нийтээс санал авахаар ЭМЯ-ны веб сайтад 30 хоног байршуулсан бөгөөд ХӨСҮТ-ийн шуурхай удирдлагын нэгж, Сүрьеэ судлалын мэргэжлийн салбар зөвлөлөөс ирүүлсэн саналыг ЗГ-ын тогтоолын төсөлд тусгасан. 2024 оны 07 дугаар сарын 24-ны өдрийн ЗГ-ын 06 дугаар тогтоолоор ЭМЯ-ны бүтцийг шинэчлэн баталсан. Тус бүтцийн дагуу Нийгмийн эрүүл мэндийн бодлогын газарт ӨХСТ, аймаг, дүүргийн НЭМТ байгуулах чиг үүрэг хамаарах болсон. | |
| **ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | |
| **2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| 1 | ЗГҮАХ 2.1.5.7<br>Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна. | - | Байгуулсан нийгмийн эрүүл мэндийн төвийн тоо | 2023 оны жилийн эцсийн байдлаар 10 аймгийн эрүүл мэндийн газрын бүтцэд нийгмийн эрүүл мэндийн төв нэртэй нэгж байна. | 10 аймаг, 3 дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна. | Тус төвийн өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээг хийж үнэлгээний дүн болон ӨХСТ-ийн ерөнхий бүтцийн төсөлтэй уялдуулан НЭМТ-ийн бүтцийг шинэчлэх төслийг боловсруулсан. Төслийг ӨХСТ байгуулахтай холбогдуулан зохион байгуулсан хэлэлцүүлгийн үеэр буюу 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдөр (Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага, Аймаг, нийслэлийн ЭМГ, Дүүргийн эрүүл мэндийн | 50 |



10

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төв,ӨЭМТ-ийн удирдах албан тушаалтан, эмч, мэргэжилтэн 67 албан хаагч оролцсон) НЭМТ-ийн дүрэм, бүтэц, үйл ажиллагааны чиглэлийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Нийгмийн эрүүл мэндийн мэргэжлийн салбар зөвлөлөөс 6/2121 тоот албан бичгийг хүргүүлэн саналыг авсан. Дээрх саналыг тусган төслийг боловсронгуй болгож байна. | |
| 2 | ЗГҮАХ 2.1.6.3<br>Дүрс архивлан хадгалах нэгдсэн тогтолцоо (PACS) бүрдүүлнэ. | 100.0 | Дүрс архивлан хадгалах систем нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | Төрөлжсөн мэргэшлийн 2 эмнэлэг дүрс архивлан хадгалах системтэй. | Эрүүл мэндийн байгууллагуудад Дүрс архивлан хадгалах систем бүрэн ашиглагдаж жигдэрсэн байна. | Эрүүл мэндийн салбарын цахимжилтыг эрчимжүүлэх Ерөнхий сайдын захирамжийн хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд хоорондоо мэдээлэл солилцох боломж бүрдсэн. Энэ хүрээнд Дүрс оношилгооны мэдээллийг архивлан хадгалах тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад бүрэн бүрдүүлсэн. Өөрөөр хэлбэл дүрс оношилгооны мэдээллийг эрүүл мэндийн байгууллагад болон Үндэсний Дата төв дээр шууд хадгалан архивлаж байна. | 100 |
| 3 | МУХТЖҮЧ-2.2.6,<br>ЗГҮАХ-2.1.6<br>МУХТ 3.3.2.6<br>Бүх шатны эмнэлэг, эмийн сангуудад ашиглагдах нэгдсэн өгөгдлийн систем үүсгэнэ. (өвчний түүх, эмчилгээний түүх, эмчийн онош, жор) | - | Системд холбогдсон эмнэлэг<br>Системд холбогдсон эмийн сан | - | 10 эмнэлэг системд холбогдсон байна.<br>10 эмийн сан системд холбогдсон байна. | Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 206 дугаар захирамжийн хүрээнд ЦХХЯ болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран "Эмийн жор", "Дүрс оношилгооны дүгнэлт", "Шинжилгээний хариу", Жирэмсний хяналтын хөтөч карт", "Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ", "Амбулаторийн карт", "Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"- | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ийн мэдээллийг И-Монгол системээр дамжуулан нэвтрүүлж эхлээд байна. 2024 оны 3 дугаар сарын 27-нд төрийн үйлчилгээний нэгдсэн системд “Эмийн цахим жорыг нээж нийт 3,200 эмийн сан болон 800 гаруй эмнэлэг HEALTH-ESB холбогдсон. Эх хүүхдийн ягаан дэвтрийг мөн холбож 5 сарын 25-нд нээлтээ хийсэн. ЭМД-ын health.gov.mn программаар ЭМД-ын байгууллагатай гэрээ байгуулсан бүх эрүүл мэндийн байгууллагууд өвчтөний өдрийн эмчилгээний түүх болон өвчний түүхийг цахимаар бөглөн хянагдаж санхүүжилтээ авч байна. | |
| 4 | ЗГҮАХ 2.1.6.4 Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ. | 500.0 | Телемедицин нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын тоо | ЭХЭМҮТ, УНТЭ, УГТЭ-т телемедицин нэвтэрсэн. | Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 31 эрүүл мэндийн байгууллагад телемедицин нэвтэрсэн байна. | Телемедицины үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулалтаар хангаж мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг сэргээн ЭМХТ-ийн Мэдээллийн технологийн албаны чиг үүрэгт тусган Эрүүл мэндийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/113 дугаар тушаалаар баталсан. 2024 оны байдлаар нийт 70 эрүүл мэндийн байгууллага үүнээс 68 анхан шатны эрүүл мэндийн байгууллага тухайлбал, Хэнтий аймгийн 26, Өмнөговь аймгийн 10, Дорноговь аймгийн 19, Өвөрхангай аймгийн 2 сумын эрүүл мэндийн төв телемедицинад шинээр холбогдож УГТЭ-ийн Зүрх | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судасны тегтэй холбогдож сургалт, зөвлөгөө мэдээллээ харилцан солилцож эхлээд байна. Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагаас Мөн ТТАХНЭ, НЭМҮТ-д телемедицин суурилуулсан. | |
| 5 | Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж батлуулна. | - | Засгийн газрын хуралдааны шийдвэр | Ажлын хэсэг байгуулагдсан | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Монгол Улсын хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1, 25.1.5-д заасны дагуу<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсанаас хойш орсон өөрчлөлтийн байдалд болон Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн нөхцөл байдлын дүн шинжилгээг хийсэн.<br>- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, мэргэжлийн салбар зөвлөл, холбоод, эрүүл мэндийн байгууллагуудаас ирүүлсэн саналуудыг нэгтгэн төсөлд тусгасан.<br>- Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн зүйл заалтад зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн<br>Хуулийн шинэчилсэн найруулгын эхний хувилбар болон үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | 62.5 |
| 6 | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай шинэчилсэн найруулга (нэмэлт, өөрчлөлт)-ын төсөл боловсруулж Засгийн газарт хүргүүлнэ. | - | Засгийн газрын хуралдааны шийдвэр | Ажлын хэсэг байгуулагдсан | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг шинэчилэн боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/53 дугаар тушаалаар батлагдсан. | 30 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн заалт бүрийг Эрүүл мэндийн тухай хуультай харьцуулан дүн шинжилгээ хийж, ажлын хэсэгт танилцуулсан. Эрүүл мэндийн тухай хуультай давхацсан заалт, нэмж оруулах шаардлагатай зүйл заалт бүр дээр ялгаж гаргасан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний төрөл, эмнэлгийн шатлал зэргээр олон улсын, дэлхийн орнуудын байдлыг судалж, ажлын хэсгийн хурлаар танилцуулсан. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулсан. | |
| 7 | ЗГҮАХ 2.1.10.1<br>Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулж батлуулна. | | УИХ-д өргөн барьсан хууль | Ажлын хэсэг байгуулагдсан. | Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж батлуулсан байна. | Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу<br>- Эрүүл мэндийн тухай хуулийн зүйл, заалтуудад хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийсэн.<br>Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн үзэл баримтлалын төслийг Хууль зүй дотоод хэргийн сайд болон Эрүүл мэндийн сайд 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хамтран баталсан. Улсын Их Хурлаас 2024 оны 07 сарын 10-ны өдөр Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хууль батлагдсантай холбогдуулан Үзэл баримтлалын төслийг дахин боловсруулж батлуулахаар ажиллаж байна.<br>Хуулийн төслийг 2024 оны эхний хагас жилд батлагдсан | 40 |



94

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинэчилсэн найруулга, нэмэлт өөрчлөлт орсон хуультай уялдуулан боловсруулах зорилгоор харьцуулалт үнэлгээ хийж байна. Эрүүл мэндийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Эрүүл мэндийн яамнаас 2025-2028 онд багтаан УИХ-д өргөн мэдүүлэхээр Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд тусгуулахаар ХЗДХЯ-нд санал хүргүүлж Засгийн газраар батлуулсан. Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулахаар ажиллаж байна. | |
| 8 | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлуулна. | - | ЗГ-ын хуралдааны шийдвэр | Хуулийн төслийн үзэл баримтлал батлагдсан. Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төсөл, баримт бичгийн бүрдүүлбэрийг боловсруулсан. | Хуулийн нэмэлт, өөрчлөлтийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн 13 хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан. Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж байна. Хуулиар захиргааны хэм хэмжээний акт гаргахаар эрх олгосон заалтын хүрээнд холбогдох стандарт, дүрэм, журмын төслүүдийг боловсруулж байна. | 100 |
| 9 | Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох | - | ЗГ-ын хуралдааны шийдвэр | - | Хуулийн төслийг ЗГ-ын хуралдаанаар | Гепатитын D вирусийн эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортлох Булевиртид эмийг | 100 |



56

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | булевиртид эмийг гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төсөл боловсруулах. | | | | хэлэлцүүлсэн байна. | Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслүүдийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн Чуулганы нэгдсэн хуралдаанаар эцэслэн баталсан. | |
| 10 | ЗГҮАХТ 4.1.4.1<br>Төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг төрийн үйлчилгээний E-Mongolia платформд холбоно. | - | Нэмэгдсэн үйлчилгээний төрлийн тоо | 21 төрлийн эрүүл мэндийн лавлагаа үйлчилгээг үзүүлж байна. | E-Mongolia платформоор дамжуулан Төрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн байна. | ЦХХХЯ, Гааль татвар санхүү мэдээллийн төв, И-Монгол академи, эмнэлгийн мэдээллийн систем хөгжүүлэгч байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн байгууллагын ашиглаж байгаа программ хангамжаар дамжуулан Эх, хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр"-ийн мэдээллийг И-Монгол системд оруулсан.<br>- Эмийн жор<br>- Дүрс оношилгооны дүгнэлт<br>- Шинжилгээний хариу<br>- Жирэмсний хяналтын хөтөч карт<br>- Хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилгын гэрчилгээ<br>- Амбулаторийн карт зэрэг<br>өнөөгийн байдлаар эрүүл мэндийн 35 төрлийн мэдээлэл E-Монголиа системээр гарч, дээрх 7 төрлийн тусламж үйлчилгээг тус системд нэмж оруулсан. Дээрх 7 тусламж үйлчилгээний хандалтын мэдээллийг E-Mongolia академитай 7 хоног бүр солилцож байна.<br>Өнөөгийн байдлаар нийт 3200 эрүүл мэндийн байгууллага E-Монголиа системд холбогдож | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүл мэндийн холбогдолтой 3,5 сая гаруй хандалт хийгдсэн байна. | |
| 11 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг шинэчилнэ. | - | ЭМДҮЗ-ийн тогтоол | ЭМДҮЗ-ийн 2023 оны 8 дугаар тогтоолоор зохицуулагдаж байна. | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам /ЭМДҮЗ-ийн 2023 оны 8 дугаар тогтоол/-ыг шинэчилж батлуулсан байна. | ЭМДҮЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 29-ны өдөр "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журмыг шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоол батлагдсан. | 100 |
| 12 | Ерөнхийлөгчийн 2019 оны 104 дүгээр зарлиг Монгол Улсын хэмжээнд амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх мэдээллийн сан бүрдүүлж, холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээтэй болгоно. | - | Батлагдсан тушаал Шинээр үүссэн мэдээллийн сан | Салбар дундын хамтарсан ажлын хэсэг байгуулсан. Журмын төслийн эхний хувилбарыг боловсруулсан. | Амиа хорлох оролдлого хийсэн болон амиа хорлосон тохиолдлыг бүртгэх маягтыг батлуулж, мэдээллийн сан үүсгэсэн байна. | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт (2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр) оруулж магадлагааг цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд бичгээр гарган магадлагааны нэгдсэн санд бүртгэдэг байх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлсэн *(38.2.Энэ хуулийн 38.1-д заасан магадалгааг цахим хэлбэрээр, шаардлагатай тохиолдолд бичгээр гаргах бөгөөд магадалгааны нэгдсэн санд бүртгэнэ.)*.<br>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн стратеги судалгааны хүрээлэнгээс 03 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан "Амиа хорлох үзэгдлийн тархалт, шалтгаан нөхцөл" хэлэлцүүлэгт "Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи | 100 |



97

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэл тандалтын журам"-ын төслийг хэлэлцүүлж, саналыг тусган "Амиа хорлох оролдлогыг бүртгэх маягт"-ыг шинэчлэн боловсруулж, Эрүүл мэндийн сайдын 611 дүгээр тушаалын шинэчилсэн төсөлд бүрэн тусгалаа. "Монгол улсын хэмжээнд амиа хорлох оролдлого, амиа хорлож нас барсан тохиолдол, архи мансууруулах бодисын хэрэглэгч болон донтогчийг бүртгэх мэдээллийн санг бүрдүүлж холбогдох байгууллагуудын нэгдсэн сүлжээг үүсгэх" сэдэвт судалгааны төслийн үр дүн, тайланг АУЁЗХХ-ны хурлаар хэлэлцүүлж судалгааг хаах дүгнэлт бүхий шийдвэр (АУЁЗХХ-ны тогтоол №24/086)-ийг батлуулсан. Мөн уг судалгааны тайланг үндэсний судалгааны нэгдсэн сангийн платформ /www.sudalgaa.gov.mn/-д байршуулав. | |
| 13 | Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг боловсруулж, батлуулна. | - | Засгийн газрын тогтоол | Журмын төслийг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. | Журам Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна. | Эрүүл мэндийн тухай хуулийн 8.4-т заасан "Эрүүл мэндийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглах, хадгалах, аюулгүй байдлыг хангах" журам- ыг боловсруулж Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 100 дугаар тогтоолоор батлуулсан. | 100 |
| 14 | ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг | - | Батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын А/399 | ӨОУ-ын 11 дүгээр ангиллыг нэвтрүүлэх бэлтгэл | Өвчний олон улсын 11 дүгээр ангиллын шинэ хувилбарт шилжих арга хэмжээ, үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлнэ. | | Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь | дүгээр тушаалаар Өвчний олон улсын арван нэгдүгээр ангилал (ICD-11)"-ыг эрүүл мэндийн салбарт нэвтрүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах болон эх хэлнээ хөрвүүлэх ажлын хэсэг байгуулагдсан. | ажлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдаж, 2024 онд төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна. | ажиллагааны календарчилсан төлөвлөгөө, 2024-2025 он"-г эцэслэн боловсруулж, Эрүүл мэндийн дэд сайдаар батлуулсан (04 дүгээр сард). Төлөвлөгөөнд тусгасны дагуу ЭМЯ-ны Мэргэжлийн салбар зөвлөлийн Ерөнхий мэргэжилтэн, гишүүдийг оролцуулсан багууд Өвчний олон улсын 11 дүгээр ангиллаас мэргэжлийн чиглэлд хамаарах өвчний бүлгүүдийг Монгол хэл рүү хөрвүүлэх үйл ажиллагаа хийгдэж байна. Нэвтрүүлэх үйл ажиллагаатай холбоотой цахим уулзалт, сургалтыг нийт 3 удаа зохион байгуулав.<br>Мөн ДЭМБ-ын Номхон далайн баруун эргийн бүсийн зөвлөхтэй хамтарсан цахим хурал зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөөг авсан. Өвчний олон улсын арваннэгдүгээр ангилал (ICD-11)"-ын орчуулах үйл ажиллагааны хүрээнд Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлтэй хамтарсан уулзалт (10 дугаар сард)-ыг зохион байгуулсан.<br>Өвчний олон улсын арваннэгдүгээр ангилал (ICD-11)"-ын орчуулах ажлыг гүйцэтгүүлэхээр Мэргэжлийн салбар зөвлөлтэй хийх гэрээний загвар боловсруулан, гэрээ хийх бэлтгэл ажлыг хангаж байна | |
| 15 | МУТЖҮЧ 2.7.4. | - | ЗГ-ын хуралдааны шийдвэр | Хүний генетикийн тухай хуулийн | Хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар | Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу | 40 |



94

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | "Хүний генетикийн тухай хууль"-ийн төслийг боловсруулна. | | | төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/111 тушаалаар батлуулсан. | хэлэлцүүлсэн байна. | - Хүний генетикийн тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагын тандан судалгааг дуусгасан.<br>- Хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл боловсруулсан.<br>- Санхүү эдийн засгийн тооцоо судалгааны урьдчилсан тооцоог хийсэн<br>Филиппин Улсад 04 дүгээр сард зохион байгуулагдсан "Нийгмийн эрүүл мэндийг сайжруулахад хүний геномикийн ололтыг нэвтрүүлэх шинжээчдийн зөвлөлдөх уулзалт"-д оролцож, бүс нутгийн улс орнуудын Хүний генетикийн эрх зүйн зохицуулалтуудтай танилцсан.<br>Хөрш улсууд болон Номхон далайн баруун эргийн бүс нутгийн бусад улсуудад мөрдөгдөж байгаа Хүний генетикийн чиглэлийн хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилт, ололт, тулгамдсан асуудлын талаарх мэдээллийг цуглуулсан. | |
| 16 | МУТЖҮЧ 2.2.5,<br>ЗГҮАХ 2.1.7.1,<br>Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг байгуулна. | - | Эрсдэлийн сангийн хэмжээ | 2023 онд 40.0 тэрбум төгрөгөөр байгуулсан. | Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 9 хувь (51,4 тэрбум)-иар байгуулсан байна. | Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хуулиар эрүүл мэндийн даатгалын сангийн орлогыг 1,964,757.3 төгрөгөөр, 2024 оны эрсдлийн сангийн хэмжээ (53,5 тэрбум төгрөг)-өөр буюу өмнөх оныхоос 13.5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан.<br>ЭМДҮЗ-ийн 2024 оны "Эрүүл мэндийн даатгалын 2024 оны эрсдлийн сангийн хөрөнгийг | 100 |



100

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зарцуулах тухай" 16 дугаар тогтоолын дагуу эрүүл мэндийн даатгалын эрсдлийн сангийн хөрөнгийг эрүүл мэндийн байгууллагын даатгуулагчид үзүүлсэн тусламж, үйлчилгээнд зарцуулж байна. | |
| 17 | ЗГҮАХ 2.1.7.3<br>Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн Улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүлнэ. | 4,500.0 | Батлагдсан урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар, Урт хугацааны тусламж, үйлчилгээнд улсын төсөв (ЭМДС)-өөс санхүүжүүл-сэн хэмжээ | Туршилтын төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө батлагдсан. | Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гарч, 20 хувийг Улсын төсөв (ЭМДС)-аас санхүүжүүлсэн байна. | Урт хугацааны тусламж, үйлчилгээний 3 өөр загварыг Төрийн өмчит аж ахуйн нэгж, хувийн хэвшлийн асрамжийн газар, сумын Нэгдсэн эмнэлгийг (Сэлэнгэ, Мандал сум) түшиглэн ГБХНХЯ, АХБ-тай хамтран хэрэгжүүлж байна.<br>- Тус төслөөр загвар байдлаар хэрэгжүүлж байгаа урт хугацааны тусламж үйлчилгээний загвар төслийн хэрэгжилтийн үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 2025 оны 2 сард тайлан гарна.<br>- 2024 оны 5 дугаар сард Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахтай холбоотой нэр томьёоны тодорхойлолт, тусламж, үйлчилгээний нэр төрлийн шинэ заалтууд оруулах санал боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1678 дугаар албан бичгээр хууль санаачлагчид хүргүүлсэн. УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт тус яамны төлөөлөл ажиллан НББХ-ны хурлаар 2 удаа, УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 удаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэлэлцэгдэн яамнаас өгсөн саналууд 100 хувь дэмжигдсэн. Хуулийн төсөл УИХ-ын нэгдсэн чуулганы 2024 оны 6-р сарын 5-ны өдрийн хуралдаанаар ёсчлон батлагдсан. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 06 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношийн хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ"-г батлуулсан бөгөөд дээрх оношийн хамааралтай бүлгийн жагсаалтад удаан хугацааны тусламж үйлчилгээ тухайлбал, хорт хавдрын болон бусад өвчний үеийн хөнгөвчлөх эмчилгээ, үйлчилгээний 1, сувиллаас үзүүлэх тусламж, үйлчилгээний 3, дагнасан сэргээн засах тусламж, үйлчилгээний 9, уламжлалт анагаах ухааны 16 оношийн хамааралтай бүлгээр санхүүжүүлж байна. Урт хугацааны тусламж, үйлчилгээний ЭМДС-ийн санхүүжилт 24,6 хувьтай байна | |
| 18 | ЗГҮАХ 2.1.7.7 Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, | - | Цахим бүртгэл нэвтэрсэн эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | - | Эрүүл мэндийн байгууллагын 60 хувьд цахим бүртгэлийн тогтолцоо нэвтэрсэн байна. | Эрүүл мэндийн үндэсний тооцооны 2016-2022 оны үр дүнг тооцож, ДЭМБ-ын бүсийн зөвлөхөөр 2024 онд хянуулан баталгаажуулж, Global Health Expenditure Report-д нийтлүүлэх | 70 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ. | | | | | болсон. Тооцооллын үр дүнг нэгтгэн "Монгол Улсын эрүүл мэндийн үндэсний тооцоо 2016-2022" нэгдсэн тайланг боловсруулсан. Тайлангийн хураангуйг "Эрүүл мэндийн үзүүлэлт 2023" номын эдийн засаг бүлэгт хэвлүүлсэн. Улсын эмнэлгүүдийн орлого зарлагын 2016-2022 оны мэдээллийг ЭМЯ-аас, ЭМДС-ийн мэдээллийг ЭМДЕГ-ийн цахим сангаас, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын зардлын мэдээллийг Татварын ерөнхий газраас авч мэдээллийн нэгдсэн сан үүсгэж дүн шинжилгээ хийв. Мөн хандивлагчдын талаарх мэдээлэл болон гадаадад эмчлүүлэгчдийн зардлын мэдээллийг Монгол банкны төлбөрийн тэнцлийн мэдээ, ТББ-ийн зардлын мэдээллийг судалгаагаар цуглуулж мэдээллийн санд нэгтгэсэн. Дээрх мэдээллийн санд нэгдсэн мэдээллийг эрүүл мэндийн байгууллагуудын хувьд санхүүгийн мэдээллийн нэгдсэн санд холбон эрүүл мэндийн салбарын ESB- д холбох үйл ажиллагааг эхлүүлээд байна. | |
| 19 | Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурыг сонгосон эрүүл мэндийн байгууллагад турших, эцэслэн сайжруулна. | - | Нэвтрүүлсэн мэдээлэл технологийн энтерпрайз архитектур | Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Эрүүл мэндийн яамны | Эрүүл мэндийн салбарын энтерпрайз архитектурыг нэвтрүүлсэн байна. | Анхан шатны эрүүл мэндийн 535, лавлагаа шатлалын 48, хувийн хэвшлийн 68 эрүүл мэндийн байгууллагыг цахим технологи ашиглан холбож, Монгол Улсын хэмжээнд нэгдсэн сан үүсгэх, мэдээллээ | 100 |



203

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан . | | хоорондоо нэг хэлээр солилцдог болсон ба эрүүл мэндийн мэдээллийн "Health-ESB" мэдээлэл солилцооны системээр дамжуулан нэгдсэн сан бүрдэж байна.<br>2024 оны 02 дугаар сараас эхлэн сервис хөгжүүлэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай хамтран зохион байгуулж байна.<br>Монгол Улсын Ерөнхий сайдын 2023.12.21-ний өдрийн 206 дугаар захирамжаар Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд систем хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх асуудлыг судалж, ESB мэдээллийн санг үүсгэж, E-Mongolia платформд зарим үйлчилгээг холбож нэвтрүүлсэн. 2024 оны 05 дугаар сард "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" сэдэвт сургалтыг нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн эрүүл мэндийн салбарын нийт 24,000 эмч, эмнэлгийн ажилтныг хамруулан бүсчилэн зохион байгуулсан. | |
| 20 | ЗГҮАХ 2.1.7.11<br>Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-ийн орлогыг нэмэгдүүлнэ. | - | Шинэчлэгдэн батлагдсан ЭМД-ын шимтгэлийн хувь | Засгийн Газрын 2023 оны 12 сарын 27-ны өдрийн ээлжит хуралдаанаар эрүүл мэндийн даатгалын | ЭМД-ын тухай хуулийн 6.1.4-т заасан даатгуулагчийн шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 6-аас | Эрүүл мэндийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн хуралдаанаар 2025 онд Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 6.1.2-6.1.11-д заасан даатгуулагч (хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн | 90 |



904

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | шимтгэлийн 2024 оны хувь хэмжээг шинэчлэн тогтоосон. | доошгүй хувиар тогтооно | сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагч, 0-18 насны хүүхэд болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, тэтгэврээс өөр тогтмол мөнгөн орлогогүй иргэн, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, хүүхдээ хоёр (ихэр бол гурав) нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх(эцэг), хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч, ял эдэлж байгаа ялтан)-ийн эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 15840 (арван таван мянга найман зуун дөчин) төгрөгөөр, мөн энэ хуулийн 6.1.12-т заасан иргэний эрүүл мэндийн даатгалын сарын шимтгэлийн хэмжээг 13200 (арван гурван мянга хоёр зуун) төгрөг байхаар хэлэлцэн дэмжсэн. “Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн 2025 оны хувь, хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, яамдаас саналыг авч байна. | |
| 21 | ЗГҮАХ 2.1.8.1 Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг нэвтрүүлнэ. | - | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл нэвтрүүлсэн эмийн сангийн эзлэх хувь | И-Монголиа платформд ХУР системээр дамжуулан “Licemed” програмаас шаардлагатай сервисүүдийг гаргах | Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг эмийн сангуудад нэвтрүүлсэн байна. | Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд ЭЭХХЗГ-ын даргын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/45 дугаар ажлын хэсэг байгуулах тушаалаар Иргэд эрүүл мэндийн байгууллагыг чанарын баталгаатай, аюулгүй эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй жигд хүртээмжтэй хангах зорилгоор систем хооронд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хөгжүүлэлт хийгдсэн. | | мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх, эм хангамжийн цахим тогтолцоог нэвтрүүлэхээр ажлын хэсэг байгуулан ажилласан. Гаалийн ерөнхий газар, Гааль татвар санхүү мэдээлэл технологийн төвтэй хамтран эмийн "Licemed" программ, Гааль болон татварын програм хооронд мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэх хөгжүүлэлт 80 хувьтай хийгдэж байна. Аж ахуйн нэгж байгууллагын тусгай зөвшөөрлийг цахимжуулан, эмийн бүртгэлийг LICEMED программ хангамжийг ГЕГ-ын мэдээлэлтэй холбон цахимжуулах зорилгоор эмийн бүртгэлийн нэгжийн зөрүүг арилган нэгтгэх ГЕГ-тай хамтран ажиллаж байна.<br>Нийт 1300 эмийн сан HEALTH-ESB сантай холбогдож цахим жороор үйлчилж байна. | |
| 22 | ЗГҮАХ 2.1.8.7 Био бэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ. | 2,500.0 | Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэ-лийн өсөлтийн хувь | 2023 онд Тэжээлт орчны үйлдвэрлэл 17.9 хувиар өссөн Био бэлдмэлийн үйлдвэрлэл шинээр 6 загвар бүтээгдэхүүн гарган авсан. | Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 35 хувиар өссөн байна. | Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталсан Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /шинэчилсэн найруулга/ - д дотоодын эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих зорилгоор үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход тухайн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд импортлох, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ хангаж нийлүүлэх эрхийг хамт олгох (Хуулийн 7.1 дэх заалт), үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сав, баглаа боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх (Хуулийн 47.18 дахь заалт), Импортыг орлох, экспортыг дэмжих, инновац шингэсэн үндэсний үйлдвэрийн шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон алслагдсан бүс нутагт эм, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэхэд төрөөс хөнгөлөлттэй зээл, санхүүгийн дэмжлэг олгох (Хуулийн 47.19 дэх заалт) зэрэг зохицуулалт тусгасан. Мөн Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 71 дүгээр тогтоолд био бэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг дэмжих зорилгоор шинжлэх ухаан, технологийн төсөл, судалгааны ажилд дэмжлэг үзүүлэх, био бэлдмэлийн үйлдвэрлэлд ашиглах түүхий эд, сав, баглаа боодол, тоног төхөөрөмжид татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох асуудлыг бодлогоор дэмжих талаар тусгаж, батлуулсан.<br><br>Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 35 хувиар өссөн байна (ЭЭХХЗГ). | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | "Алсын хараа-2050" 2.2.26, ЗГҮАХ 2.1.8.9 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ. | 500.0 | Тогтмол баяжилт хийгдсэн эмнэлгийн тоног төхөөрем-жийн бүртгэл | 2023 онд эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программд 588 эрүүл мэндийн байгууллагын 1,181 хэрэглэгч, 31,163 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн. | Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд тогтмол баяжилт хийсэн байна. | 2024 оны 05 дугаар сарын 31 буюу эхний хагас жилийн байдлаар эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлийн программд 597 эрүүл мэндийн байгууллагын 1,218 хэрэглэгч, 32,396 эмнэлгийн тоног төхөөрөмж бүртгэгдсэн. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн бүртгэлд тогтмол баяжилт хийгдсэн байна. | 100 |
| 24 | ЗГҮАХ 2.1.9.4 Эрүүл мэндийн ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг цалин урамшуулалтай уялдуулан эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг дээшлүүлнэ. | - | Батлагдсан тушаал 2024 онд шинээр ёс зүй харилцаа хандлагын урамшууллыг олгодог болсон эрүүл мэндийн байгууллагын тоо | Эрүүл мэндийн ажилтанд ур чадварын нэмэгдэл олгох журмын төслийг боловсруулсан. | Журам боловсруулж, батлуулсан байна. Цалин урамшууллыг ёс зүй харилцаа, хандлагатай уялдуулж олгодог эрүүл мэндийн байгууллагын тоо нэмэгдсэн байна. | Ур чадварын нэмэгдэл олгох 3 сайдын хамтарсан тушаалын төсөлд яамдаас ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулж, ЭМС-ын 2024-04-04-ны 1а/1365 тоотоор ХНХЯ, СЯ-д хүргүүлсэн. Сангийн сайдын 2024-05-15 01/3882 тоотоор "Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хууль"-ийн төсөл тусгаж шинэчлэхээр ХНХЯ-тай хамтран ажиллаж байгаа талаар ирүүлсэн. Засгийн газрын 2024 оны 83,84,128 дугаар тогтоолууд батлагдаж, эдгээр тогтоолыг үндэслэн нэмэгдлийг олгож байна. | 80 |
| 25 | МУТЖҮЧ 2.2.8 ЗГҮАХ 2.1.9.5, Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ. | | Батлагдсан тушаал Төлөвлөсөн арга хэмжээний | ЗГ-аар батлагдсан үндэсний хөтөлбөр | Нийгмийн хамгааллын арга хэмжээний төлөвлөгөө батлагдаж, 2024 | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/102 тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Эрүүл мэндийн салбарын 2024-2026 хамтын хэлэлцээр батлуулах ажлын хэсэг | 50 |



18

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | хэрэгжилтийн хувь | хүчингүй болсон. | онд төлөвлөсөн арга хэмжээ хэрэгжсэн байна. | 3 удаа хуралдан гэрээний төслийг хэлэлцэж, гэрээ батлагдсан. Мөн Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, дунд хугацааны зорилтот хөтөлбөрүүд, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, эрүүл мэндийн салбарын хууль эрх зүйн орчны шинэчлэл, тусламж, үйлчилгээний эрэлт, хэрэгцээтэй уялдуулан эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг 2026 он хүртэл дунд хугацаагаар төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |
| 26 | МУТЖҮЧ 9.1.2<br>ЗГҮАХ 2.1.13.1<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн эрх зүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрүүдийг сонгон нэвтрүүлнэ. | - | Батлагдсан тушаал | 2017, 2021, 2022 онд батлагдсан эрх зүйн баримт бичгийг мөрдөж байна. | Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм, гүйцэтгэлийн гэрээний журам, гэрээний шалгуур, шалгуур үзүүлэлт, сонгон шалгаруулалтын журмуудыг шинэчлэн батлуулсан байна. | ЭМСайдын 2024 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/122 тушаалаар ӨЭМТ-ийн гүйцэтгэлийн гэрээ байгуулах, хэрэгжилтийг дүгнэх, гэрээг сунгах, дуусгавар болгох журам, 2024 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн А/320, А/321 тушаалаар Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэм, Өрхийн эрүүл мэндийн төвийн сонгон шалгаруулалтын журмуудыг тус тус шинэчлэн батлуулсан. | 90 |
| | | - | Үнэлгээний тайлан | Өрхийн эрүүл мэндийн төвийн зохион байгуулалтын хувилбарыг Чингэлтэй, Хан-Уул | Туршилтын загвар үнэлгээ хийнэ. | Үйлчлүүлэгч төвтэй тусламж, үйлчилгээг хөгжүүлэх, тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор анхан болон лавлагаа шатлал хооронд интеграцчлалын эмнэл зүйн, үйл ажиллагаа, үйлчилгээний | 90 |



109

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дүүрэгт 2023 оны 10 сараас турших эхэлсэн. | | хувилбаруудыг НЭМГ-ын даргын 2023 оны 140 дүгээр тушаалаар Чингэлтэй, Хан-уул дүүрэгт туршилтаар хэрэгжүүлж, 2024 оны 5-6 сард явцын үнэлгээ хийгдсэн.<br>Үнэлгээгээр дүүргийн ЭМТ, НЭ эмнэлэг, ӨЭМТ-ийн ашиглаж буй цахим программууд хоорондоо уялдахгүй, ӨЭМТ-ийн тогтмол зардлыг шийдвэрлээгүй, эмнэлгийн менежмент, интеграцийн үйл ажиллагааны талаар ойрхон солигдож байгаа эмнэлгийн удирдлагууд ойлголт дутмаг тулгамдсан асуудлууд нь төслийн хэрэгжилтэд нөлөөлж байгааг тодорхойлсон. Төслийн эцсийн үнэлгээ 2024 оны 12 дугаар сард хийгдэж тайлан гарна.<br>Эмнэл зүйн интеграциын хүрээнд артерийн гипертензи, чихрийн шижин, өөх тосны солилцооны алдагдал, сүрьеэ зэрэг 4 өвчний оношилгоо, эмчилгээний менежментийг сайжруулахад өрх дүүргийн ЭМТ нэгдсэн сүлжээнд орж, архаг өвчний менежментийг багаар хэрэгжүүлж байна.<br>Үйлчилгээний интеграцийн хүрээнд лавлагаа шатлалд үйлчлүүлэгч шилжүүлэх, буцаан анхан шатанд хяналтанд авах эргэх холбоог сайжруулах ажлууд хийгдэж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 27 | ЗГҮАХ 2.1.13.2<br>Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ. | - | Шалгуурын дагуу санхүүжилтээ бүрэн авч буй өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эзлэх хувь | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэн баталсан. | Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн байна. | ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 29-ны өдрийн "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоол батлагдан гарсан. Тогтоолд Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/283 дугаар тушаалаар гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг тусгаж, ЭМДС-аас үзүүлсэн тусламж, үйлчилгээг санхүүжүүлж байна. ЭМДС-аас 2024 онд өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийг санхүүжүүлэх санхүүжилтийг бүрэн олгосон. | 100 |
| 28 | ЗГҮАХ 2.1.13.4<br>Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчилнэ. | - | Батлагдсан тушаал | ЭМДҮЗ-ийн 2023 оны 06 дугаар тогтоолоор зохицуулагдаж байна. | Журам шинэчлэн батлагдсан байна. | ЭМДҮЗ-ийн 2024 оны "Төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" 05 дугаар тогтоолоор өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилтийг тооцох журмыг шинэчлэн баталсан. Журамд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амын эрсдэлийн бүлгийн коэффициент, нэг иргэнд ногдох зардлын хэмжээ, орон нутгийн цалингийн нэмэгдлийн коэффициент, газар зүйн коэффициентыг тооцон олгохоор тусгасан. | 100 |
| 29 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төсөл боловсруулна. | - | ЭЗХЯ-нд хүргүүлсэн санал | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. | Хөтөлбөрт эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний төслийг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт салбарын чиглэлээр газар, хэлтсээс санал авч боловсруулан ЭЗХЯ-д 1а/3129 албан бичгээр хүргүүлсэн. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөтөлбөр УИХ-ын 2024 оны 21 тогтоолоор батлагдсан. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан Удирдлагын зөвлөлөөр 2024 оны 11 дүгээр сарын 14-нд хэлэлцүүлэн гишүүдийн саналыг тусган ЭЗХЯ-нд 1а/4611 тоот албан бичгээр хүргүүлсэн | |
| 30 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох журам боловсруулж батлуулна. | - | Батлагдсан журам | Журмын төслийг боловсруулсан. | Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдаар батлуулсан байна. | 2023 онд Ур чадварын нэмэгдэл олгох 3 сайдын хамтарсан тушаалын төсөл боловсруулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Тушаалын төслийг ЭМС-ын 2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 1а/5460 дугаар албан бичгээр ХНХЯ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. 2024 онд яамдаас ирүүлсэн саналыг тусган дахин боловсруулж, ЭМС-ын 2024-04-04-ны 1а/1365 тоотоор ХНХЯ, СЯ-д хүргүүлсэн. Сангийн сайдын 2024-05-15 01/3882 тоотоор “Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай хууль”-ийн төсөл тусгаж шинэчлэхээр ХНХЯ-тай хамтран ажиллаж байгаа талаар ирүүлсэн. | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 31 | “Эрүүл мэндийн байгууллагад цахим орчинд үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах журам“ батлуулна. | - | Батлагдсан тушаал | 2019 оны Эрүүл мэндийн сайдын Мэдээллийн аюулгүй байдлын журмаар зохицуулагдаж байна. | Журмыг шинэчлэн батлуулсан байна. | “Эрүүл мэндийн байгууллагад цахим орчинд үйлчлүүлэгчийн нууцлалыг хангах журам“-ын судалгаа хийгдэж байна. | 30 |
| 32 | Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журам батлуулна. | - | Батлагдсан тушаал | - | Журмыг боловсруулж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Хиймэл оюун ухааныг эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах туршилт судалгааны 2 төсөл (ЭХЭМҮТ-д “Умайн хүзүүний хорт хавдар, хавдрын урьдал эмгэгийн эрт илрүүлэгт хиймэл оюун ухаан ашиглах нь” олон улсын байгууллагын санхүүжилттэй төсөл, УАУТХ-нд “Уламжлалт анагаах ухааны оношилгооны аргуудад хиймэл оюун ухааны технологийг ашиглах нь” ШУТС-ийн санхүүжилттэй, БШУЯ-ны захиалгат төсөл)-д судалгаа эхлүүлэх зөвшөөрөл олгосон.<br><br>Үндэсний түвшинд хэрэгжиж байгаа эрт илрүүлэг арга хэмжээний их өгөгдлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх судалгааны багийн ажлын хүрээнд цээжний рентген зургийн болон зүрхний цахилгаан бичлэгийн мэдээллийг хиймэл оюун ухааны програмчлалд холбох судалгааг УГТЭ-ийг түшиглэн эхлүүлж эхний үр дүнг хүлээн авсан. | 50 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | “Эрүүл мэндийн салбарт хиймэл оюун ухааныг эмчилгээ, оношилгоонд ашиглах журам”-ын төслийг боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, яамны газар хэлтсийн дарга нараар хянуулж байна. | |
| 33 | Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж батлуулна. | - | Батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/598 дугаар тушаалаар “Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэл 2020-2025 он“ батлагдсан. | Тэргүүлэх чиглэлийг шинэчлэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна | Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох хэрэгцээ шаардлагын үнэлгээ, тандалтын судалгааг эхлүүлж эрүүл мэндийн эрдэм шинжилгээний байгууллагуудаас мэдээлэл цуглуулсан.<br>Эрүүл мэндийн салбарын шинжлэх ухаан, технологийг 2025-2029 онд хөгжүүлэх тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зорилгоор тэргүүлэх чиглэлийн жагсаалтад санал авах болон тодотгол хийх маягтуудыг түүнийг бөглөх удирдамж зааврын хамт боловсруулсан. ЭМЯ-ны харьяа тусгай мэргэжлийн төвүүд, анагаахын чиглэлээр боловсрол олгодог их дээд сургуулиуд, эрүүл мэндийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхэлдэг салбарын бус хүрээлэнгүүдийн дарга захирал нарт Эрүүл мэндийн сайдын 2024 оны 1а/4516 тоот албан бичгээр тэргүүлэх чиглэлийн санал ирүүлэх хүсэлтийг | 80 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж хариуг авсан. Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажлын хэсэг болон ажлын хэсэгт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх шинжээчдийг багийн бүрэлдэхүүнийг батлах Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг яамны газар, хэлтсийн дарга нараар хянуулж байна. Түүнчлэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх төсөл, үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг тодорхойлох асуудлаар шинжээчдийн баг (5 хүн)-ийг эрүүл мэндийн сайдын томилгоогоор томилж, шинжээчдийн ажлын удирдамжийг (2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр) Эрүүл мэндийн сайдаар батлуулсан. Шинжээчдийн багийг нийт 3 удаа хуралдуулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологи нэвтрүүлэх тэргүүлэх чиглэлийн төслийг боловсруулж, 07 дугаар сарын 09-ний өдрийн ШУТЗ-ийн 2 дугаар хурлаар хэлэлцүүлсэн. "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд дэвшитэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл (2024 он)"-ийг боловсруулж Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/347 дугаар тушаал (1 дүгээр хавсралт)-аар батлуулсан. | |



115

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 34 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн шинэчилсэн найруулгын 36.1.2, 36.4 дэх заалт. "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах" журам боловсруулна. | - | Засгийн газрын тогтоол | - | Журам Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 42 дугаар тогтоолоор "Олон улсын чанарын шаардлага хангасан хүний эм, эмнэлгийн хэрэгсэл, био бэлдмэл, вакциныг гадаад улсын үйлдвэрлэгчээс, эсхүл олон улсын байгууллагаас шууд болон дамжуулан худалдан авах журам" батлагдсан. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллах тухай Бодлого төлөвлөлтийн газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 4/646 тоот албан бичгийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, тусгай эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн удирдлагуудад хүргүүлсэн. Журмын хүрээнд Эрүүл мэндийн сайд 2024 оны 09 дүгээр сарын 22-25 -ны өдрүүдэд БНСУ-д ажлын айлчлал хийж тус улсын эм үйлдвэрлэгч байгууллагуудтай уулзалтууд хийсэн. БНСУ-ын Dongkoo Bio & Pharm. Hanmi Pharm, CKD, Hanlim pharm, Yuhan Corporation, Korea United Pharm зэрэг үйлдвэрүүдээс зүрх судас, чихрийн шижин, хоол боловсруулах эрхтний эмгэгийн болон хавдрын хими эмчилгээний эмүүдийг Монгол улсад нийлүүлэх хэлцлүүд үргэлжилж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Одоогоор Dongkoo Bio & Pharm үйлдвэрээс 5, CKD үйлдвэрээс 4, Hanmi pharm үйлдвэрээс 5, Hanlim pharm үйлдвэрээс 4 нийт 18 төрлийн эм импортлохоор хэлцэл хийсэн. Dongkoo Bio & Pharm, CKD үйлдвэрүүд нийлүүлэх эмээ Монгол улсын хүний эмийн бүртгэлд бүртгүүлэхээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт бүртгэлийн материалаа хүлээлгэн өгөөд байна. Yuhan corporation, Hanmi pharm, Korea United Pharm зэрэг үйлдвэрүүдтэй 20 гаруй нэр төрлийн хавдрын хими эмчилгээний тариаг импортлох боломжийг нээхээр хэлцэл хийж байна. Япон улсаас эм импортлох боломжийг нээхээр судалгааны ажил хийгдэж байна. | |
| 35 | Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгодог эмийн жишиг үнийг шинэчилнэ. | - | ЭМДҮЗ-ийн тогтоол | ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолоор зохицуулагдаж байна. | Эрүүл мэндийн даатгалын сангаас хөнгөлөлттэй олгодог эмийн жишиг үнийг шинэчилж, батлуулсан байна | ЭМДҮЗ-ийн 2024 оны 06 дугаар тогтоолын 4, 5 дугаар хавсралтаар төлбөрийг нь төр хариуцах эмийн жагсаалт болон эмийг олгох зохицуулалтыг тусгасан. ЭМДЕГ-тай хамтран ЭМДҮЗ-ийн 2022 оны 11 дүгээр тогтоолын хэрэгжилтэд нөхцөл байдлын дүн шинжилгээ, үнэлгээг хийсэн. Тус тогтоолын хэрэгэжилтийн явцад шинээр нэмүүлэх 64 эмийн санал, үнийн дээд хязгаар нэмүүлэх 129 эмийн санал, ӨОУА-ын код нэмүүлэх 22 эмийн саналд холбогдох судалгааг хийж, шинэчилсэн тогтоолын төсөлд 247 оношийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүрээнд 259 ерөнхий нэршилд хамаарах 1413 эмэнд үнийн хөнгөлөлт олгохоор тусгаж өгсөн. Тогтоолын төсөлд 2024 оны 1а/3580 дугаар бичгээр санал хүргүүлсэн. Тогтоолын төслийг ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | |
| 36 | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолуудын хэрэгжилтийг дүгнэж санал боловсруулна. | - | Үнэлгээний дүн | - | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолуудын хэрэгжилтэд үнэлгээ хийн дүгнэж, холбогдох санал, зөвлөмжийг хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албатай хамтран хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 18 тогтоолын хэрэгжилтэд үнэлгээ хийсэн . Тогтоолын хэрэгжилт 97.7% байна. Үнэлгээгээр 2022 оны 01,11, 2023 оны 06, 08 дугээр тогтоолыг шинэчлэх шаардлагатай байгааг тодорхойлж, үнэлгээний дүнг ЭМДҮЗ-ийн хурлаар хэлэлцүүлсэн. Дээрх тогтоолыг шинэчлэхээр ЭМЯ, ЭМДҮЗ, ЭМДЕГ хамтран холбогдох судалгааг тооцоог хийж, тогтоолын төсөл боловсруулж, ЭМДҮЗ-ийн хурлаар 2 удаа хэлэлцүүлж, шийдвэрлүүлсэн. ЭМДҮЗ-ийн 2024 оны 02, 05, 06 дугаар тогтоол шинэчлэгдэн батлагдсан. 2022 оны 11 тогтоол, 2023 оны 13 дугаар тогтоолыг шинэчлэн батлуулахаар холбогдох судалгаа, шинжилгээг хийж, шинэчилсэн тогтоолын төслийг боловсруулж, ЭМДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 37 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчилнэ. | - | ЭМДҮЗ-ийн тогтоол | ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор зохицуулагдаж байна. | Сонгон шалгаруулалтыг 3 жилд нэг удаа нэгдсэн журмаар зохион байгуулж байгааг өөрчлөн хугацааны зохицуулалтыг хийж журмыг батлуулсан байна. | ЭМДҮЗ-ийн 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдан гарсан. Тогтоолоор эрүүл мэндийн салбарын тэргүүлэх чиглэлд багтсан, хүртээмж хангалтгүй байгаа тусламж, үйлчилгээгээр нэмэлт сонгон шалгаруулалт зохион байгуулж байна. | 100 |
| 38 | Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт 08 /ҮАМАТ/-д нэмэлт өөрчлөлт оруулж батлуулна. | - | Батлагдсан тушаал | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А/119 дүгээр тушаал хэрэгжиж байна. | Үндэсний ажил, мэргэжлийн ангилал ба тодорхойлолт-08-д ороогүй ажил мэргэжлүүдийг нэмж оруулах, хөдөлмөрийн хортой нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлуулна. | Зоонозын өвчин судлалын салбарт ажиллаж байгаа нийт 397 албан хаагчдын ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийсэн. Үнэлгээний дүнг үндэслэн Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 12 дугаар тогтоолоор Зоонозын өвчин судлалын салбарт ажиллаж байгаа бактериологич, амьтан болон шимэгч судлагч, биохимич зэрэг ажилтнуудад албан тушаалын үндсэн цалингийн 30 хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдлийг тухайн албан тушаалыг эрхлэх хугацаанд сар бүр олгохоор шийдвэрлэсэн. | 50 |
| 39 | Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль 18.1<br>Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний төсөл боловсруулна. | - | ЭЗХЯ-нд хүргүүлсэн санал | Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө батлагдсан. | Эрүүл мэндийн салбараас төлөвлөгөөнд тусгах үйл ажиллагааны саналыг ЭЗХЯ-нд хүргүүлсэн байна. | Эрүүл мэндийн салбараас төлөвлөгөөнд тусгах үйл ажиллагааны саналыг боловсруулан 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 1а/300 албан бичгээр ЭЗХЯ-нд хүргүүлсэн. | 100 |
| 40 | Эх баригчийн ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан тушаал | Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/216 | Эх баригчийн ажлын байрны тодорхойлолтын үлгэрчилсэн | Эрүүл мэндийн сайдын 2024 оны 06 сарын 14-ны өдрийн А/289 дүгээр тушаалаар батлуулсан. | 100 |



119

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | дугаар тушаалыг мөрдөн ажиллаж байна. | загварыг шинэчилж, батлуулсан байна. | | |
| 41 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2027 он хүртэлх төлөвлөлтийг тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээнд тулгуурлан хийнэ. | - | Хүний нөөцийн 2026 он хүртэлх батлагдсан төлөвлөлт | Өмнө гаргасан хүний нөөцийн урт хугацааны тооцоо, төлөвлөлт 2020 онд дуусгавар болсон. | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2027 он хүртэлх хэрэгцээний тооцоо, төлөвлөлт хийгдсэн байна. | АШУҮИС-тай хамтран Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн 2026 он хүртэх төлөвлөлт судалгаа хийгдсэн. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А446 дугаар тушаал аар нийгмийн эрүүл мэндийн сувилагч бэлтгэх асуудлаар холбогдох эрх зүйн баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн хуралдааныг 2 удаа зохион байгуулж, 2024-2026 онд хэрэгжүүлэх ажлын нарийвчилсан төлөвлөгөө гарган ажиллаж байна. | 40 |
| 42 | “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж батлуулна. | - | Батлагдсан журам | Эрүүл мэнд спортын сайд, Сангийн сайдын 2015 оны 97/56 дугаар тушаалаар зохицуулж байна. | Журам шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. | 2023 онд дахин ажлын хэсэг хуралдуулан, нөлөөллийн шинжилгээнд тооцоо судалгаа нэмсэн. Тушаалын төсөлд удирдлагуудаас дахин санал авсан. | 40 |
| 43 | Салбарын 3 талт хэлэлцээрийн хэрэгжилтийг дүгнэж шинэчлэн батална. | - | Хэлэлцээрийн хэрэгжилтийн тайлан<br><br>Шинээр батлагдсан 3 талт хэлэлцээр | 2021-2023 оны хэлэлцээр хэрэгжсэн. | Салбарын 3 талт 2024-2026 оны хэлэлцээрийг байгуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/102 тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Эрүүл мэндийн салбарын 2024-2026 хамтын гэрээ 7 бүлэг 85 заалттай 2024-05-30 нд батлагдсан. | 100 |



190

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.2. Сайд, дэд сайд, удирдлага болон яамны аппаратын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| 1 | Эрүүл мэндийн сайдтай Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2024 онд хамтран ажиллах гэрээг байгуулна. | - | Гарын үсэг зурж, баталгаажсан гэрээ | Гэрээг жил бүр байгуулдаг. | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар 2024 онд хамтран ажиллах гэрээг байгуулсан байна. | Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн засаг дарга нартай 2024 онд хамтран ажиллах гэрээнд 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр талууд гарын үсэг зуран баталгаажуулсан. | 100 |
| 2 | Хүн амын эрүүл мэндийн эрэлт, хэрэгцээг үндэслэн эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэлийг батлуулна. | - | Батлагдсан тушаал | 2018 оны тушаалаар зохицуулагдаж байгаа. | Тэргүүлэх чиглэл шинэчлэгдэн батлагдсан байна. | Монгол Улсын хүн амын эрэлт, хэрэгцээнд тулгуурлан 2024-2027 онд эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэргүүлэх чиглэл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хязгаарлах, олгохгүй чиглэлийг батлах тухай Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, Эрүүл мэндийн яамны газрын дарга нараар тойруулж зуруулан батлуулахад бэлэн болсон | 90 |
| 3 | Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шалгуур үзүүлэлтийг шинэчлэн батлуулна. | - | Батлагдсан тушаал | Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалын төсөл, тушаалын төслийн нөлөөллийн шинжилгээ, танилцуулгыг боловсруулсан. | Шалгуур үзүүлэлт шинэчлэгдэн батлагдсан байна. | Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлж байгаатай холбоотой “Эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, протез үйлдвэрлэх, импортлох, ханган нийлүүлэх, засвар үйлчилгээ | 90 |



191

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрхлэх зөвшөөрөл авахад мөрдөх шалгуур үзүүлэлтийг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 2/3928 дугаар албан бичгээр Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт зохицуулалтын газарт шилжүүлэв.<br>- Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ эрхлэх ажлын байранд үнэлгээ хийх хяналтын хуудас (нийтлэг шаардлага болон өвөрмөц шаардлагаар), ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх бодис худалдах болон үйлчилгээ эрхлэх, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, ханган нийлүүлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудас, хүний эм, эмнэлгийн хэрэгслийг жижиглэнгийн үнээр хангах үйл ажиллагаа эрхлэх байгууллагын ажлын байрны үнэлгээ хийх хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, ЭЭХХЗГ, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүдээс санал авч, батлуулахад бэлэн болсон. | |
| 4 | Тоон гарын үсэг нэвтрүүлнэ. | - | Тоон гарын үсэг ашиглаж буй эрүүл мэндийн байгууллагын эзлэх хувь | E-Health эмнэлгийн програм хангамж ашигладаг 48 эмнэлгийн 17385 эмч, эмнэлгийн | ЭМБ-ын 50 хувь нь тоон гарын үсэг ашигладаг болсон байна. | ЦХХХЯ, Гааль татвар санхүү мэдээллийн төв, И-Монгол академи, эмнэлгийн мэдээллийн систем хөгжүүлэгч байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн байгууллагын ашиглаж байгаа програм хангамжаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | мэргэжилтэн тоон гарын үсэг ашиглаж байна. | | дамжуулан иргэн Эрүүл мэндийн байгууллагаас үйлчилгээ авахад<br>-Иргэний гар утсанд код илгээх<br>-E-mongolia-гаар мэдэгдэл хүргэх,<br>- Хурууны хээ уншуулах<br>-Тоон гарын үсгээр баталгаажуулах боломжийг бүрдүүлж өгсөн.<br>Дээрх үйлчилгээг төрийн өмчийн 72, хувийн 212 нийт 284 эрүүл мэндийн байгууллагад нийт 15000 эрүүл мэндийн салбарын ажилтан тоон гарын үсгийг ашиглаж байна. | |
| 5 | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулна. | - | Үйл ажиллагааны тайлан | - | Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулсан байна. | Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/393 дугаар тушаалаар "Эрүүл мэндийн салбарын 7 хоног" арга хэмжээг 2024.10.17-19 хооронд зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн салбарын Удирдах ажилтны зөвлөгөөнийг 2024 оны 10 дугаар сарын 17-нд Төрийн захиргаа удирдлагын газартай хамтран зохион байгуулсан. | 100 |
| 6 | Шаардлагатай харьяа байгууллагуудын бүтэц дүрмийг шинэчилнэ. | - | Батлагдсан тушаал | 2023 онд яамны харьяа 4 байгууллагын бүтэц дүрмийг шинэчлэн баталсан. | Шаардлагатай харьяа байгууллагуудын бүтэц дүрмийг шинэчилж, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | Эрүүл мэндийн сайдын 2024.06.07-ны өдрийн А/274 дүгээр "Улсын нэгдүгээр төв эмнэлгийн дүрэм шинэчлэн батлах тухай", 2024.03.05 өдрийн А/133 дугаар "Эрүүл мэндийн хөгжлийн төв"-ийн дүрэм, бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулах тухай тушаалууд тус тус батлагдсан. | 100 |
| 7 | Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг | - | Батлагдсан тушаал | - | Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын | Нийслэлийн харьяа 25 ЭМБ-ын бүтэц, дүрэм, орон тоо баталсан | 80 |



185

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсронгуй болгох загвар батлуулна. | | | | орон тоо, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох загварыг боловсруулж, батлуулсан байна. | эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж дүгнэлт хийсэн. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулиар баталсан нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх байгууллагын төрөл батлагдсан, Нийслэлийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох төслийг боловсруулж байна. Мөн Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль (Шинэчилсэн найруулга) 2024 оны 06 сарын 05 ны УИХ-аар соёрхон батлагдсан. Хуулийн 4.4 дүгээр зүйлд 100000-с доошгүй хүн амтай, дэд бүтэц хөгжсөн, улсын эдийн засаг нийгмийн хөгжилд онцгой ач холбогдолтой хотыг Улсын зэрэглэлтэй байхаар заасан. Нийслэлийн төвийн 6 дүүргийн хүн ам тус бүр 100000-с дээш тул хуулиар улсын зэрэглэлтэй хот болох эрх зүйн орчин бүрдсэн байна. Тус хуулийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө. Хуулийн хэрэгжилтэй уялдуулан дүүргийн ЭМТ, нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох боломжтой юм. | |

**Нэг. Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээний)-ын биелэлт:**

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ***Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 12 дугаар тэмдэглэл:*** Эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, Эрүүл мэндийн төрөлжсөн мэдээний сан болон мэдээлэл солилцох системийн талаар эрүүл мэндийн байгууллагад сургалт зохион байгуулах, иргэдэд зориулсан нөлөөллийн аян өрнүүлэх арга хэмжээ авах | Сургалтын тоо, сургалтад хамрагдсан хүний тоо | | Эрүүл мэндийн салбарын нийт ажилтнуудын 30-50 хувийг сургалтад хамруулах | Энэ ажлын хүрээнд Эрүүл мэндийн сайдын "Сургалт зохион байгуулах тухай" 2024 оны А/177 дугаар тушаалыг боловсруулж батлуулсан. Дээрх тушаалаар байгуулсан ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, 05 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймагт "Төрийн бүтээмжийн сэргэлт-Цахим эрүүл мэнд" сургалтыг зохион байгуулж, нийт (24800) орчим эмч, эрүүл мэндийн ажилтныг сургалтад хамруулсан.<br><br>"Төрийн бүтээмжийн сэргэлт-цахим эрүүл мэнд" сургалтын нэгдсэн тайлан (161 хуудастай) гарсан. | 04 дүгээр сарын 05-ны өдрөөс 06 дугаар сарын 06 /25-ны өдөр хүртэл | 100 |
| 2 | ***Монгол Улсын хөгжлийн урт хугацааны бодлогын баримт "Алсын хараа – 2050" 2.2.5, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 2.2.2, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2.1.1, Эрүүл мэндийн*** | Судалгааны ажлын явц, хувиар | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/498 дугаар тушаалаар судалгааны багийг байгуулсан, судалгаан | | Ажлын хэсгийн "их өгөгдөл " дээр ажиллах чадавхийг сайжруулах 2 өдрийн сургалтыг Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр ЭМХТ-тэй хамтран зохион байгуулж, нийт 20 судлаачдыг хамруулсан. | 2024.01.01-05.01 | 100 |



185

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ***сайдын 2022 оны А/139 дугаар тушаал:***<br><br>Эрт илрүүлгийн мэдээний санг ашиглан халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийн судалгааг хийнэ. | | ы арга аргачлал Эрдмийн зөвлөл, АУЁЗХХ-оор хэлэлцэгдэж, судалгаа эхлүүлэх зөвшөөрлийг авсан. | | Сүүлийн 2 жилийн хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан (нийт **1,543,479** хүн) тав хүртэлх насны болон 6-17 насны нийт 578,473 хүүхдийн, 18-аас дээш насны нийт 446,410 насанд хүрэгчдийн мэдээлэл (их өгөгдөл)-д халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тооцоолол, дүн шинжилгээг хийж, судалгааны тайланг хэвлэлд шилжүүлсэн. “Эрт илрүүлэг-Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг”-ийг 12 дугаар сарын 06-ны өдөр АШУҮИС-тай хамтран зохион байгуулав. | | |
| 3 | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэнтэй холбогдуулан Дотоодын эм (уламжлалт эм), биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжсэн УИХ-ын тогтоолын төсөл боловсруулах. | Улсын Их Хурлын тогтоол | 0% | Тогтоолын төслийг Нийгмийн бодлогын байнгын хороо, УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн байна. | Дотоодын эм (уламжлалт эм), биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг дэмжих талаар Монгол Улсын Их Хурлын “Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” тогтоолын төсөл боловсруулж, Нийгмийн бодлогын байнгын хороо, УИХ-ын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлсэн Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 71 дугаар тогтоолоор баталсан. | 2024 оны 4-6 сар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Түр орлон ажилласан хугацаанд ирсэн албан бичиг өргөдөл, гомдол шийдвэрлэх | - | Ирсэн албан бичиг, өргөдөл | Ирсэн албан бичиг, өргөдлийг шийдвэрлэсэн байна | - Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд Засгийн газрын тогтоолын 6 төсөлд саналыг албан бичгээр хүргүүлсэн.<br>- Сангийн яаманд хамтран ажиллах талаар 2024.03.12-ны 2/1024 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>- Боловсрол, шинжлэх ухааны яаманд 2024.01.05-ны 1а/46, 2024.03.30-ны 1а/1799 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.<br>- Цахим хөгжүүлэгч бүх компанид 2024.03.21-ний 4/1168 дугаар албан бичиг<br>- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоонд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох тогтоол, тушаал, шийдвэрийг хэрэгжүүлсэн чиглэлээр тайлбар мэдээллийг 2024.02.03-ны 4/766, албан бичгээр хүргүүлсэн.<br>- Монголын эрүүл мэндийн ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоонд Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын цалин, хөлс, нийгмийн баталгааны асуудлаар 2024.04.29-ны 1а/1792 дугаартай албан бичгээр мэдээлэл хүргүүлсэн. | 2024.01.01-05.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Хүний эрхийн үндэсний комисст Зоонозын өвчин судлалын албан хаагчдаас ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэхэд 2024.02.06-ны 4/526 дугаар албан бичгээр тайлбар мэдээллийг хүргүүлсэн. | | |
| 5 | ХНХЯ-ны сайдын 2023 оны А/155, А/221 дүгээр тушаалын хэрэгжилтийг хангах, эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл хүргүүлэх | Хүргүүлсэн албан бичиг | - | Хүргүүлсэн албан бичиг | Төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын дарга нарт 2024.02.20-ны 4/710 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | 2024.01.01-02.20 | |
| 6 | Эрүүл мэндийн салбарын 2024-2026 хамтын хэлэлцээр батлуулах ажлын хэсэг | | - | Гэрээ батлагдсан байх | Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/102 тушаалаар ажлын хэсэг байгуулагдсан. Эрүүл мэндийн салбарын 2024-2026 хамтын хэлэлцээр батлуулах ажлын хэсэг 3 удаа хуралдан гэрээний төслийг хэлэлцэж,7 бүлэг 85 заалттай 2024-05-30 нд гэрээ батлагдсан. | 2024-03-15 2024-06-01 | 100 |
| 7 | ***Төрийн нарийн бичгийн даргын үүрэг даалгавар:*** Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах | Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд өгсөн санал | - | Хуулийн төсөлд санал боловсруулж тусгах | - Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд яамны холбогдох газруудтай хамтран санал боловсруулж Хууль зүй, Дотоод хэргийн сайдад 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 1а/1678 албан бичгээр хүргүүлсэн. Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон | 2024.04.30 2024.06.01 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах УИХ-ын НББХ-ны дэд ажлын хэсэгт ажиллаж тус хууль, дагалдаж гарах 11 хуулийн төслийн боловсруулалтад хамтран ажилласан. Хуулийн төсөл УИХ-ын нэгдсэн чуулганы 2024 оны 6-р сарын 5-ны өдрийн хуралдаанаар ёсчлон батлагдсан. | | |
| 8 | ***Төрийн нарийн бичгийн даргын үүрэг даалгавар:*** Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт Процессын дахин инженерчлэлийн ажлын хэсэгт ажиллах | Салбарын нөхцөл байдлын дүн шинжилгээ боловсруулах | - | Процессийн дахин инженерчлэл боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээ хийсэн байх | "Процессийн дахин инженерчлэлийн талаар авах арга хэмжээний тухай " Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 419 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хэсэгт ажилласан.<br>Эрүүл мэндийн салбар дахь процессын дахин инженерчлэлийн судалгаа хийхийн зэрэгцээ бизнес процессын дахин инженерчлэл, процесс зураглал, төслийн удирдлага, манлайлал, багийн ажиллагаа, харилцааны удирдлага, судалгааны арга зүй зэрэг сэдвүүдээр 7 удаагийн сургалтад хамрагдсан.<br>Төслийн багаас гаргасан "Процессын дахин | 2024.03.18<br>2024.04.23 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | инженерчлэлийн судалгаа, шинжилгээ хийх ажлын удирдамж"-ийн дагуу эрүүл мэндийн салбарын нөхцөл байдлын шинжилгээг хийн яамны 70 албан хаагчтай чиг үүргийн шинжилгээний ярилцлага, яамнаас гадагшаа чиглэсэн 22 үйл ажиллагаанд процессийн судалгаа хийн зургийг зурж, 3 удаа 34 оролцогчтойгоор фокус бүлгийн ярилцлага зохион байгуулсан. | | |
| 9 | ***Төрийн нарийн бичгийн даргын үүрэг даалгавар:*** Салбарын хуулиар эрх олгосон захиргааны хэм хэмжээний актад дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд захиргааны хэм хэмжээний актаар зохицуулж байгаа харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах. | Засгийн газрын хуралдааны 2023 оны 48 дугаар тэмдэглэлтийн хэрэгжилт хангагдсан байна. | - | Хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэн ХЗДХЯ-нд тогтоосон хугацаанд хүргүүлэх. | Монгол Улсын Засгийн газрын хуралдааны 48 дугаар тэмдэглэлээр өгсөн үүрэг чиглэл болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан "Захиргааны хэм хэмжээний актыг цэгцлэн хуулийн төсөл боловсруулах ажлын удирдамж"-ийг хэрэгжүүлэх чиглэлээр Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн А/07 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулж, Хууль зүй дотоод хэргийн яамнаас ирүүлсэн захиргааны хэм хэмжээний акт гаргахаар хуулиар эрх олгосон зохицуулалтын судалгаа, эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж байгаа захиргааны хэм хэмжээний улсын нэгдсэн санд бүртгэлтэй 91 шийдвэрт дүн | 01-3 сар | 100 |



150

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | шинжилгээ хийж цаашид авах арга хэмжээний саналыг боловсруулан. Эрүүл мэндийн сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 1а/854 тоот албан бичгээр Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. | | |
| 10 | Амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгүүдийг Нийслэлийн харьяанд шилжүүлэх | Засгийн газрын тогтоол | - | Засгийн газрын тогтоол батлагдсан байна. | “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд яамдаас санал авч нэгтгэн 2023.12.14-ний өдрийн 1а/5715 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2023.12.20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн 460 дугаар тогтоолоор эцэслэн батлагдсан. | 2023.09<br>2023.12 | 100 |
| 11 | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтын хүрээнд “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам” боловсруулах | Засгийн газрын тогтоол | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн өөрчлөлт УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаан аар хэлэлцэгдэ н батлагдсан | Журам Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна. | “Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, хяналт тавих журам”-ын төсөлд яамдаас 2024.01.09-ний өдрийн 1а/90 албан бичгээр санал авч нэгтгэн боловсруулж 2024.02.15-ны өдрийн 1а/639 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Засгийн газрын 2024.02.28-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн 78 дугаар тогтоолоор эцэслэн батлагдсан. | 2024.01<br>2024.04 | 100 |



151

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Эмч нарын их хурал зохион байгуулах тухай Засгийн газрын тогтоолоор шийдвэр гаргуулах | Засгийн газрын тогтоол | - | Засгийн газрын тогтоол батлагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн "Эмч нарын их хурал зохион байгуулах тухай" 261 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Монголын Эмч нарын VII их хурал" -ыг 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Их хуралд УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн яам, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, сум, дүүрэг, өрхийн эрүүл мэндийн төв зэрэг төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага, Монгол Улс дахь Нэгдсэн үндэстний байгууллагын төрөлжсөн байгууллагын төлөөлөл зэрэг 850 гаруй төлөөлөгч оролцож, цахимаар нийт 1442 санал, хурлын "Хэлэлцүүлэг-1"-ийн явцад 23 асуулт, "Хэлэлцүүлэг-2"-ын явцад 7 асуулт, санал тус тус гарсан. гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн | 2024.04<br>2024.06 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хурлаар хэлэлцүүлж, холбогдох газар, хэлтсүүд 2025 оны жилийн төлөвлөгөөндөө тусгаж, хэрэгжилтийг хангаж ажиллах шийдвэр гарсан | | |
| 13 | Халдварт өвчинтэй тэмцсэн түүх, хуримтлуулсан мэдлэг, ухаарал боть-1 | Ном гарсан байх | - | Ном хэвлэгдсэн байна | Эрүүл мэндийн салбарын олон улсын онцгой комисс бусад байгууллагуудын тайланг нэгтгэн шинжлэх ухааны акдемитай хамтран 100 гаруй тайлан мэдээ, ХБНГУ, түүхийн судар бичгийг эх сурвалж болгон гаргасан. 2024.12.05 хэвлэгдсэн /1500ш албан хэрэгцээнд/ | 2023.06.01-2024.12.05 | 100 |
| 14 | Коронавируст халдвар "КОВИД-19" цар тахлын үед хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн боть-2 | Ном гарсан байх | - | Ном хэвлэгдсэн байна | Цар тахлын үеийн төрийн албан хаагчид болон Засгийн газраас гаргасан бодлогын арга хэмжээнүүдийг үйл явдлын товчооны дараалалаар гаргалаа. | 2023.06.01-2024.12.05 | 100 |
| 15 | Коронавируст халдвар "КОВИД-19" цар тахлын үеийн туршлага, сургамж, боть-3 | Ном гарсан байх | - | Ном хэвлэгдсэн байна | Цар тахлын үеийн сургамж, туршлагыг хэлэлцэж нийт 267 илтгэлийг хэлэлцүүллээ. Хэлэлцүүлэгт цахимаар 7000 гаруй танхимаар 200 эрдэмтэн судлаачид оролцлоо. 2024.05.06 | 2023.03.01-05.06 | 100 |
| 16 | Монгол улс цар тахлыг даван туулсан нь, боть-4 | Фото альбом гарсан байх | - | Ном хэвлэгдсэн байна | Фото альбом нь Монгол улсын цар тахлын үеийн үйл ажиллагаа, арга хэмжээг зураг хэлбэрээр үйл явдлын товчооны дараалалаар хийсэн. УОК, Монголын | 2023.06.01-2024.12.05 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зурагчдын холбоо, ЭМЯ хамтран бүтээсэн. | | |
| 17 | Эрт илрүүлэг-эрдэм шинжилгээний хурал, судалгааны үр дүнгийн тайлан | Арга хэмжээ зохион байгуулагдаж тайлан гарсан байна | - | Ном хэвлэгдсэн байна | Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/498 дугаар тушаалаар судалгааны багийг байгуулсан, судалгааны арга аргачлал Эрдмийн зөвлөл, АУЁЗХХ-оор хэлэлцэгдэж, судалгаа эхлүүлэх зөвшөөрлийг авсан.<br>Ажлын хэсгийн "их өгөгдөл " дээр ажиллах чадавхийг сайжруулах 2 өдрийн сургалтыг Азийн хөгжлийн банкны төслийн санхүүжилтийн дэмжлэгтэйгээр ЭМХТ-тэй хамтран зохион байгуулж, нийт 100 гаруй судлаачдыг хамруулсан.<br>Сүүлийн 2 жилийн хугацаанд эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан (нийт **1,543,479** хүн) тав хүртэлх насны болон 6-17 насны нийт 578,473 хүүхдийн, 18-аас дээш насны нийт 446,410 насанд хүрэгчдийн мэдээлэл (их өгөгдөл)-д халдварт болон халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тооцоолол, дүн шинжилгээг хийж, судалгааны тайланг нэгтгэлээ.<br>Эрт илрүүлэг-эрдэм шинжилгээний хурал, | 2023.06.01-2024.12.05 | 100 |



154

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | хэлэлцүүлгийг 2024.12.06-ны өдөр АШУҮИС-тай хамтран 300 гаруй эрдэмтдийг оролцож арга хэмжээг зохион байгуулж нийт 40 ханын илтгэл, 15 аман илтгэлийг хэлэлцүүлж дүгнэлт, зөвлөмж, товлолын саналыг аван тайланг гаргалаа. Цахимаар 10 000, танхимаар 300 гаруй судлаачид оролцон санал, шүүмж, дүгнэлтийг өглөө. | | |
| 18 | Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах | Худалдан авах эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрлийг сонгож нэг эх үүсвэр, олон улсын байгууллага эсвэл үйлдвэрлэгчээс худалдан авсан байна. | - | Иргэдэд ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй олгож буй эм, эмнэлгийн хэрэгслийн нэр төрөлд үнэлгээ хийж, өндөр дүнгээр санхүүжилт олгосон эмийг нэг эх үүсвэрээс худалдан авах боломжийг судлан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар болон бусад холбогдох | Монгол Улсад хэрэглэгдэж байгаа хүний эмийн чанар, аюулгүй байдлыг сайжруулах зорилтын хүрээнд чанартай, үр нөлөөтэй эмийг боломжийн үнээр ханган нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрч, эмийн зохицуулалт, хяналтын чиг үүргийг өндөр түвшинд гүйцэтгэдэг хэмээн үнэлэгдсэн БНСУлсаас өндөр чанартай эмийг боломжийн үнээр импортлон, ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй олгох, улсын эрүүл мэндийн байгууллагуудад нийлүүлэхээр ажиллаж байна.<br>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн нэмэлт | 2024.08.26<br>2024.12.31 | 80 |



55

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | байгууллагад хүргүүлсэн байна. | өөрчлөлт /36.1.2/, Засгийн газрын 2024 оны 42 дугаар тогтоолын дагуу нэг эх үүсвэрээс эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажлын хүрээнд хэлцэл хийж буй БНСУлсын Dongkoo Bio & Pharm Co.,LTD үйлдвэртэй 2024 оны 10 дугаар сарын 25 өдөр 5 нэр төрлийн эм, Korea United Pharm Inc үйлдвэртэй 2024 оны 11 дүгээр сарын 15 өдөр 5 нэр төрлийн хавдрын хими эмчилгээний тариа, Chong Kun Dang Pharm үйлдвэртэй 4, Hanmi pharm үйлдвэртэй 4, Hanlim pharm Co., LTD үйлдвэртэй 5 нэр төрлийн эм татан авахаар 2024 оны 11 дүгээр сарын 20 өдөр гэрээ байгуулагдсан. Одоогоор ЭМДаатгалын сангаас хөнгөлөлттэй олгох 16, Төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудад хэрэглэгдэх 7, нийт 23 нэр төрлийн эмийг нэг эх үүсвэрээс худалдан авахаар боломжийг бүрдүүлээд байна.<br>Нэг эх үүсвэрээс татан авах эмийн эхний эмүүд болох Dongkoo Bio & Pharm эмийн үйлдвэрийн чихрийн шижин, артерийн даралт бууруулах, цусан шингэлэх 5 нэр төрлийн эм 2024 оны 11 сарын 29 – ны өдөр Монгол улсад ирсэн ба 2024 оны 12 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | дугаар сарын 02 өдөр Азифарм ХХК гаалийн бүрдүүлэлт хийж хүлээн аваад байна. Тус 5 нэр төрлийн эмийг 2024 оны 12 дугаар сарын 10 өдөр зах зээлд нийлүүлж эхэлсэн. Hanmi Pharm, Chong Kun Dang pharm, Hanlim pharm, Korea United Pharm үйлдвэрүүдийн эмийг 2024 оны 12 сардаа багтаан оруулж ирэх төлөвлөгөөтэй байна. БНСУлсаас нэг эх үүсвэрээс худалдан авч буй эмүүдийн CIP үнэ нь ижил төрлийн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хүлээн зөвшөөрсөн зохицуулалтын байгууллагатай улсын эмийн үйлдвэрүүдийн нийлүүлж буй эмийн үнээс 15-92% хүртэл хямд байна. Мөн ЭМД-ын сангаас хөнгөлөлттэй олгох эмүүд нь иргэд төлөх болон ЭМД-ын сангаас олгох санхүүжилтийг 50% хүртэл бууруулах тооцоо байна | | |
| 19 | Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах журмыг батлуулах. | Эрүүл мэндийн сайдын тушаалаар Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөлийн бүрэлдэхүүн, | - | Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн | Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2024 оны 06 дугаар сард Улсын Их хурлаар батлагдан, 2024 оны 10 дугаар сарын 01-ээс мөрдөж байна. Уг хуулинд эмнэлгийн хэрэгслийн | 2024.08.26<br>2024.12.31 | 80 |



47

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | түүний ажиллах журмыг баталсан байна. | | зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллаж, журмыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулсан байна. | бүртгэлийн асуудлыг эмийн бүртгэлтэй хамт зохицуулж тушаал гаргахаар заагдсан тул эмнэлгийн хэрэгслийн зохицуулалтыг нэмж тусган төслийг боловсруулаад байна. Төсөлд санал авахаар ЭМЯ-ны цахим хуудсанд 2024 оны 11 сарын 15-ны өдөр байршуулсан. Мөн Хүний эмийн зөвлөлийн хуралд хэлэлцүүлж санал авхаар гишүүдэд хүргүүлээд байна. 2024 оны 12 дугаар сарын 10 өдөр Азийн хөгжлийн банкны техник туслалцааны TA6652 төслийн дэмжлэгтэй ЭМЯ, ЭЭХХЗГ, Эм ханган нийлүүлэх байгууллага, Эмийн үйлдвэрүүд, бүртгэлийн шинжээч нарыг оролцуулсан хэлэлцүүлгийг "UB Grand" зочид буудалд зохион байгуулав.<br>Эмийн зөвлөл, Эмнэлгийн хэрэгслийн зөвлөл болон түүний салбар зөвлөлүүдийн гишүүдийг нээлттэй сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/218 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хуралдаанаар Нээлттэй сонгон шалгаруулалтын | | |



58

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | зарыг байгууллагын www.mmra.gov.mn (http://www.mmra.gov.mn/) албан ёсны цахим хуудаст 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс 11 дүгээр сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд хүлээн авахаар байршуулсан боловч сонгон шалгаруулалтад материал хангалтгүй ирсэн тул 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн ажлын цаг дуустал ажлын 10 хоногийн хугацаатай материал дахин хүлээн авах зарыг байгууллагын цахим хуудаст тус тус байршуулсан. | | |
| 20 | 6 настны сургуульд суурилсан эрт илрүүлэг үзлэгийн "Eruulhuuhed.mn" системийн нэвтрүүлэх | Нэвтрүүлсэн платформ | - | 6 настны зүрх, шүд, нүдний эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан хүүхдүүдийн цахим бүртгэл үүссэн байна. | 2024 оны 10 дугаар сарын 15-аас 6 настны сургуульд суурилсан зүрх, шүд, нүдний үзлэгийн үзлэг бүртгэлийн системийг нэвтрүүлж дуусгасан. Одоогийн байдлаар 41 мянган хүүхэд Улаанбаатар хотын хэмжээнд үзлэгт хамрагдхаас 52 хувь нь хамрагдаж үзлэгийн дүн гарсан байна. | 2024.10.15<br>2024.12.31 | 100 |

ТАЙЛАН ГАРГАСАН:

.......................... ......................... / .......................... / 2024.12.10

*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*